



МОНГОЛ УЛСЫН
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМ

15170 Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай 3,
Утас: 7600 3333, Факс: (976-11) 32 29 04,
И-мэйл: info@mcud.gov.mn, Вэбсайт: www.mcud.gov.mn

2018. 10. 29 № 03/4184
танай 2018. 10. 29 ны № 03/8643-Т

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ТАМГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА, ЭРХЭЛСЭН
КОМИССАР З.БААСАННЯМ ТАНАА

Танаас ирүүлсэн “Мэдээлэл хүсэх тухай” албан бичгийн дагуу барилгын салбарын ил тод байдлын санаачилгын хүрээнд хийсэн ажлын талаарх мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: 7 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА С.МАГНАЙСҮРЭН



08 03979

Мэдээллийн ил тод байдал

Д/Д	Барилгын салбарын ил тод байдлын санаачилгын хэрэгжилт	Холбогдох хуулийн заалт	Үр дүн
1	<p>Салбарын хэмжээнд мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, сайдын болон төрийн нарын бичгийн даргын тушаал, норм дүрмүүдийг https://mcud.gov.mn/Id?typeld=6 цахим хаягт байршуулан тухай бүр шинэчлэн ажиллаж байна.</p> <p>Иргэдэд үзүүлэх үйлчилгээг боловсронгуй болгох талаар төрийн зарим үйлчилгээг гэрээний үндсэн дээр ТББ-дад шилжүүлж гүйцэтгүүлж байна.</p>	<p>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль</p> <p>11.1.3.тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бусад мэдээлэл. 14.1.Энэ хуулийн 3.1-д заасан байгууллага нь тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжид нийтэд мэдээлэхийг хориглоогүй мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд өгөх үүрэгтэй.¹</p>	<p>Мэдээллийн ил тод байдал сайжирснаар мэдлэг, мэдээлэл бүхий олон нийтийн оролцоог хангасан бодлого, үйл ажиллагааны төлөвлөлтөд эерэг нөлөө үзүүлсэн.</p>
2	<p>Барилгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, геодезийн тусгай зөвшөөрөл, барилгын салбарын мэргэжилтнийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх сургалт эрхлэх чиг үүргийг барилгын салбарын түншлэлд гэрээгээр гүйцэтгүүлж байна.Тухайлбал: “Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг гүйцэтгүүлэх тухай” гэрээг “Монголын барилгын</p>	<p>Барилгын тухай хууль</p> <p>18 дугаар зүйлийн 18.2-т “Энэ хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн барилгын ажлыг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд эрхэлнэ.”², 18.4-т “Энэ хуулийн 18.2-</p>	<p>Төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийн хүртээмжтэй, шуурхай байдал нэмэгдсэн.</p>

¹ Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн “3.1.Энэ хууль нь улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг дараах байгууллагад хамаарна:”

² Барилгын тухай хуулийн

“10.1.2.бага төвөгшилтэй барилга байгууламж;
 10.1.3.дунд зэргийн төвөгшилтэй барилга байгууламж;
 10.1.4.өндөр төвөгшилтэй барилга байгууламж;
 10.1.5.онцгой төвөгшилтэй барилга байгууламж.

	<p>үндэсний ассоциаци” төрийн бус байгууллагатай 2018 оны 01-р сарын 25-ны өдөр байгуулан ажиллаж байгаа бөгөөд 2018/18 дугаар уг гэрээний хэрэгжилтийн нөхцөл байдалд тухай бүр үнэлгээ өгч ажиллаж байна. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг салбарын төрийн бус байгууллага “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ /төрийн бус байгууллагуудын түншлэл/-тэй ажил гүйцэтгэх гэрээний хэрэгжилтийн байдлын талаар барилга, хот байгуулалтын яамны mcud.gov.mn, https://tz.mcud.gov.mn/, http://mnca.mn хаягаар орж мэдээллийг авах боломжтой.</p>	<p>т заасан барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох, барилгын салбарын хуулийн этгээдийг бүртгэх үйл ажиллагааг төрийн бус, мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.”</p>	
3	<p>Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэн ба аж ахуй нэгж байгууллагууд tz.mcud.gov.mn хаягаар хандаж хүсэлтээ илгээж шийдвэрлүүлдэг болсон.</p>	<p>Барилгын тухай хууль 18.4-т “Энэ хуулийн 18.2-т заасан барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох, барилгын салбарын хуулийн этгээдийг бүртгэх үйл ажиллагааг төрийн бус, мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.”</p>	<p>Цахим хэлбэрт шилжүүлсэнээр олон шат дамжлаг дамжиж хүний гараар шалгадаг байсан ажлын ачааллыг багасгаж, инженер техникийн ажилчдын давхцалыг арилгаж, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааг чанаржуулах томоохон алхам болсон. Мөн энэхүү программ нь төрийн байгууллагуудын мэдээлэл солилцооны системд</p>

			холбогдож, Боловсрол, соёл шинжлэх ухаан спортын яам, Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар зэрэг байгууллагуудын мэдээлэлтэй тулгалт хийж шалгах боломжтой болсон.
4	Барилгын ажил эхлүүлэх үргэлжлүүлэх, барих хүсэлт хүлээн авах шийдвэрлэх, өргөдөл гомдлыг шийдвэрлэх талаарх мэдээллийг Нийслэлийн хот төлөвлөлт ерөнхий төлөвлөгөөний газрын http://mpa.ub.gov.mn/?p=143 цахим хаягт байршуулан ажиллаж байна.	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль 11.1.3.тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бусад мэдээлэл. 14.1.Энэ хуулийн 3.1-д заасан байгууллага нь тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжид нийтэд мэдээлэхийг хориглоогүй мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд өгөх үүрэгтэй. ³	Энэ мэдээллийг ил тод байршуулснаар барилга байгууламжийг барих, эхлүүлэх, үргэлжлүүлэх үйл ажиллагаа хот төлөвлөлтийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдах боломж бурдсэн.
5	Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн ажлын хүрээнд байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээллийг хэрэглэгчдэд түргэн шуурхай түгээх зорилгоор https://geoportal.nsdi.gov.mn хаягийг ажиллуулж байна. Үүнд: - Улаанбаатар хотын газар хөдлөлтийн бичил мужлал	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль 11.1.3.тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бусад мэдээлэл. 14.1.Энэ хуулийн 3.1-д заасан байгууллага нь тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжид нийтэд мэдээлэхийг хориглоогүй	Хот төлөвлөлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажил эмх цэгцтэй, ойлгомжтой болоход нөлөөлж байна.

³ Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн “3.1.Энэ хууль нь улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг дараах байгууллагад хамаарна:”

	<ul style="list-style-type: none"> - Улаанбаатар хот, Төв аймаг - Зуунмод хот орчмын төлөвлөлтүүд - Бэлчээрийн фото мониторинг - Хөдөө аж ахуйн мэдээ, мэдээлэл - Газрын дуудлага худалдааны байршил - Геологи орчны мэдээллийн сан (туршилт) - Нийгэм эдийн засгийн мэдээллийн сан - Авто болон төмөр замын төлөвлөлт 	мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд өгөх үүрэгтэй. ⁴	
6	<p>Газрын биржийн цахим систем: Газар зохион байгуулалтын бүх төрлийн төлөвлөгөө, Газрын кадастрын мэдээллийн сан болон Үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцийн экологи, геологи орчны мэдээллийн сантай давхцуулан байршилд сууринласан дээрх мэдээ, мэдээллийг www.mle.mn хаягаар авах боломжтой. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа - Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалт - Газар өмчлөх болон эзэмших эрхээ бусдад шилжүүлэхтэй холбогдсон арилжаа - Газар, үл хөдлөх эд хөрөнгийн зах зээлийн үнэ болон газартай холбоотой бусад мэдээлэл 	<p>Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль</p> <p>10.2.2.газрын мэдээллийн улсын санг бүрдүүлэх, хөтлөх, нийтэд үйлчлэх үйл ажиллагааг зохицуулах;</p> <p>10.2.7.газрын нэгдмэл сангийн үндсэн, дэлгэрэнгүй ангилалд орж байгаа өөрчлөлт, хөдөлгөөний талаархи тайланг Засгийн газарт жил бүр гаргаж, энэ талаархи мэдээллээр нийтэд үйлчлэх;</p>	<p>Газрын хууль бус наймаанаас урьдчилан сэргийлэх, газар зохион байгуулах, төлөвлөлтийн бусад үйл ажиллагааг явуулахад зерэг нөлөөтэй байна.</p>

⁴ Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн “3.1.Энэ хууль нь улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг дараах байгууллагад хамаарна:”

7	<p>Интернет орчинд гар утас ашиглан Газартай холбоотой бүхий мэдээллийг www.gazar.gov.mn хаягаар олон нийт авах боломжийг бүрдүүлсэн.</p> <p>Өргөдлийн дугаар, Регистрийн дугаараар хайх</p> <ul style="list-style-type: none"> - Өргөдлийн төрөл - Өргөдөл өгсөн огноо - Өргөдлийн явц - Хариуцсан мэргэжилтэн - Шилжүүлсэн мэргэжилтэн - Мэргэжилтний утасны дугаар <p>Нэгж талбарын дугаар, гэрээний дугаар хамт хайх</p> <ul style="list-style-type: none"> - Газар ашиглалтын төрөл - Гэрчилгээний дугаар - Гэрээ байгуулсан огноо. - Гэрээний дуусах хугацаа - Газрын төлбериийн мэдээлэл - Газрын төлбөр төлсөн байдал - Талбайн хэмжээ <p>Аймаг, сум, хаягаар хайх</p> <ul style="list-style-type: none"> - Нэгж талбарын дугаар - Талбайн хэмжээ - Баг/хороо - Хаягийн мэдээлэл <p>Хэрэглэгчийн нэр, нууц үг ашиглан хайх</p> <ul style="list-style-type: none"> - Нэг удаа газар өмчилсөн эсэх 	<p>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль</p> <p>11.1.3.тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бусад мэдээлэл. 14.1.Энэ хуулийн 3.1-д заасан байгууллага нь тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжид нийтэд мэдээлэхийг хориглоогүй мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд өгөх үүрэгтэй.⁵</p>	<p>Газрын хууль бус наймаанаас урьдчилан сэргийлэх, газар зохион байгуулах, төлөвлөлтийн бусад үйл ажиллагааг явуулахад эерэг нөлөөтэй байна.</p>

⁵ Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн “3.1.Энэ хууль нь улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг дараах байгууллагад хамаарна:”

	<ul style="list-style-type: none"> - Газар ашиглалтын төрөл - Захирамжийн огноо - Нэгж талбарын дугаар - Талбайн хэмжээ - Хаягийн мэдээлэл - Захирамжийн дугаар - Захирамжийн огноо - Өргөдлийн дугаар <p>Обектын мэдээлэл харах</p> <ul style="list-style-type: none"> - Нэгж талбарын дугаар - Хаягийн мэдээлэл - Талбайн хэмжээ - Зориулалт 		
8	<p>Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусlamжаар хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн талаарх мэдээллийг яамны https://mcud.gov.mn/as/projectnews цахим хаягт байршуулан мэдээллийг тухай бүр шинэчилж байна.</p>	<p>Шилэн дансны тухай хууль</p> <p>6.9. Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, Засгийн газар, түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжлийг байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын</p>	Хуулиар ногдуулсан үүргийн хүрээнд ил тодоор мэдээлдэг. Иргэдийн итгэл, оролцоо нэмэгдэж байна.

		<p>дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно. Мэдээллийг төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулахад энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд төлбөр төлөхгүй.</p>	
9	Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл, Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрхтэй аж ахуйн нэгжийн жагсаалтыг байгууллагын https://mcud.gov.mn/as/tz цахим хаягт байршуулан тухай бүр шинэчилж байна.	<p>Газрын тухай хууль 19.1.3.газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжлийн байгууллагын эрх олгох, цуцлах, тэдгээрийн ажиллах журам, зааврыг батлан мөрдүүлэх;</p> <p>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 11.1.3.тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бусад мэдээлэл. 14.1.Энэ хуулийн 3.1-д заасан байгууллага нь тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжид нийтэд мэдээлэхийг хориглоогүй</p>	<p>Мэдээллийн ил тод байдал сайжирснаар мэдлэг, мэдээлэл бүхий олон нийтийн оролцоог хангасан бодлого, үйл ажиллагааны төлөвлөлтөд эерэг нөлөө үзүүлсэн.</p>

		мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд өгөх үүрэгтэй. ⁶	
10	Барилгын материал үйлдвэрлэлийн салбарт тус яам 2012 оноос Монголын Барилгын Материал Үйлдвэрлэгчдийн Холбоотой барилгын материал үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлаар урьдчилсан дүгнэлт гаргахад шаардлагатай бэлтгэл ажлыг зохион байгуулах чиг үүргийг гүйцэтгүүлэх тухай гэрээг байгуулан ажиллаж байна.	Барилгын тухай хууль 36 дугаар зүйлийн 1-д “Төрөөс үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас энэ хуулийн 18.4, 34.2, 44.7-д заасны дагуу шилжүүлсэн чиг үүргийг төрийн бус, мэргэжлийн байгууллагаар гэрээний үндсэн дээр шилжүүлэн гүйцэтгүүлж болно.” ⁷	МБҮХолбоо нь барилгын материал үйлдвэрлэгч хүсэлтээ ирүүлсэн тохиолдолд тухайн үйлдвэрт дүгнэлт гаргах зөвлөмжийн баг ажиллуулан тусгай зөвшөөрөл олгох ажлыг хөнгөн шуурхай олгох ажлыг зохион байгуулж байна. Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд 739 аж ахуй нэгж барилгын материал үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

⁶ Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн “3.1.Энэ хууль нь улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг дараах байгууллагад хамаарна:”

⁷ 18.4.Энэ хуулийн 18.2-т заасан барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох, барилгын салбарын хуулийн этгээдийг бүртгэх үйл ажиллагааг төрийн бус, мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.

34.2.Энэ хуулийн 34.1.2, 34.1.3, 34.1.4, 34.1.6, 34.1.7, 34.1.8, 34.1.9, 34.1.10, 34.1.11, 34.1.13, 34.1.14, 34.1.15-д заасан чиг үүргийг эрх бүхий байгууллагын шийдвэрийн үндсэн дээр төрийн бус, мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

44.7.Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох асуудлыг гэрээний үндсэн дээр төрийн бус, мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.